



МОНГОЛ УЛСЫН
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Журам батлах тухай

АШУУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдааны 2021 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 21/02/02 тоот тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ:


1. "Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2020-2021 оны хичээлийн жилийн 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга (А.Шийрэвнямба) болон бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэ журмыг мөрдөх өдрөөс эхлэн захирлын 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/156 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.
4. Журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал (Б.Дамдиндорж)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ХҮРЭЛБААТАР

3350210028

АШУУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2021 оны 09 дугаар сарын 09 өдрийн
А/28 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



АШУУИС-ИЙН ТӨГСӨЛТИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт, БСШУ-ны сайдын А/370 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, БСШУ-ны сайдын 113 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын иргэдийг суралцуулах журам”, АШУУИС-ийн дүрмийн 5.1, 5.4, 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн магистр, докторын сургалт болон докторын дараах судалгаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. АШУУИС-ийн төгсөлтийн сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл бүхий хөтөлбөрт үндэслэн зохион байгуулна.


Хоёр. Сургалтын төрөл, хэлбэр, төлөвлөгөө

- 2.1 Төгсөлтийн сургалт нь магистр, докторын сургалт, докторын дараах судалгаа гэсэн төрөлтэй байх бөгөөд сургалтыг танхимын, цахим, хосолсон хэлбэрээр зохион байгуулна.
- 2.2 Магистр, докторын сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөнд төгсөлтийн сургалтын багц цаг, мэргэжлийн чиглэл, индекс, хичээлийн бүлэглэл, судлах дарааллыг тусгасан байна.
- 2.3 Магистр, докторын хөтөлбөрийн төлөвлөгөөг АШУУИС-ийн хөтөлбөрийн хороо хэлэлцэж, АШУУИС-ийн захирал батална.

Гурав. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1 Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын нэгж нь АШУУИС-ийн Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар (ТСБЗГ) байна.
- 3.2 ТСБЗГ нь дараах ажил үүргийг хариуцна. Үүнд:
 - 3.2.1 Төгсөлтийн сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах
 - 3.2.2 Төгсөлтийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах
 - 3.2.3 Хөтөлбөрийг гадаад, дотоодын магадлан итгэмжлэх эрх бүхий байгууллагаар магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулах
 - 3.2.4 Тухайн хичээлийн жилд бүрэлдэхүүн сургууль, тэнхимээс ирүүлсэн саналыг тусган элсэлтийг зохион байгуулах
 - 3.2.5 Суралцагч (магистрант, докторант, докторын дараах судлаач), удирдагчтай гурвалсан гэрээ байгуулах, магистр, докторын ажлын урьдчилсан хэлэлцүүлэг ба хамгаалалтад орох зөвшөөрөл, тодорхойлолт өгөх, төгсөгчдөд эрдмийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах
 - 3.2.6 Суралцагчдын шилжилт, хөдөлгөөнийг шийдвэрлэж, АШУУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулах


- 3.2.7 Суралцагч, удирдагч, зөвлөхийн мэдээллийг их сургуулийн удирдлага мэдээллийн системд бүртгэлжүүлэх
- 3.2.8 Төгсөлтийн сургалтын багш, удирдагч, зөвлөх нарын гүйцэтгэлийг “АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”-ын дагуу тооцно.
- 3.3 Багш, удирдагч, зөвлөхөд тавигдах шаардлага
 - 3.3.1 Төгсөлтийн сургалтын багш, удирдагч, зөвлөх нь тухайн чиглэлээр доктор (PhD) ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, сүүлийн 3 жилд гадаад, дотоодын хөндлөнгийн хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна.
 - 3.3.2 Нарийн мэргэшсэн гадаад, дотоодын судлаачийг гэрээт багшаар ажиллуулж болно.
- 3.4 Удирдагчийн эрх, үүрэг:
 - 3.4.1 Удирдагч нь суралцагчийн судалгааны ажлыг удирдаж, хянах
 - 3.4.2 Суралцагчийн сэдэв сонгох эрдмийн эрх чөлөөг хүндэтгэх
 - 3.4.3 Суралцагчийн судалгааны ажлын төлөвлөгөө, арга зүйг боловсруулах, хүрэх үр дүнг тодорхойлох, хэвлэн нийтлүүлэх, урьдчилсан хэлэлцүүлэг, эрдмийн зэргийн хамгаалалт хийх зөвшөөрлийг өгөх
 - 3.4.4 Суралцагч судалгаа боловсруулалтын явцад хууль эрх зүй, ёс зүй, байгууллагын дотоод дүрэм, журам, удирдамжийг мөрдөж байгаа эсэхийг хянах
 - 3.4.5 Суралцагч судалгааны ажлаа төлөвлөгөөний дагуу хийгээгүй, үр дүн гарган авах бололцоогүй тохиолдолд удирдагчаар ажиллахаас татгалзаж болно. Суралцагч, удирдагч, зөвлөхийн саналыг харгалзан магистрантын удирдагч, зөвлөхийг мэргэжлийн тэнхим, докторантын удирдагч, зөвлөхийг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөл шийдвэрлэж, ТСБЗГ-т хүргүүлэх
 - 3.4.6 Гэрээнд өөрөөр заагаагүй бол судалгааны үр дүнгээр туурвисан бүтээлийн хамтран зохиогч, оюуны өмчийн хамтран эзэмшигч байх
 - 3.4.7 Суралцагчийн ажил, мэдлэг, үр чадвар, төлөвшилтийн талаарх тодорхойлолтыг бичгээр өгөх
 - 3.4.8 Суралцагчийн судалгааг хугацаанд нь хийлгэж хамгаалуулах
 - 3.4.9 Магистрант, докторантын удирдагч, зөвлөхөөр ажиллаж байгаа гэрээт багш нь АШУҮИС-ийн багштай ижил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 3.5 Зөвлөхийн эрх, үүрэг:
 - 3.5.1 Зөвлөх нь судалгааны ажлын загвар, арга зүй, үр дүнг бичих, нийтлүүлэх, хэлэлцүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх
 - 3.5.2 Гэрээнд өөрөөр заагаагүй бол суралцагчийн судалгааны үр дүнгээр туурвисан бүтээлийн хамтран зохиогч, оюуны өмчийн хамтран эзэмшигч байна.
- 3.6 Суралцагчийн эрх, үүрэг:
 - 3.6.1 Суралцагч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.6.1.1 АШУҮИС-ийн дүрэм, бусад холбогдох журмуудад заасан боловсролын үйлчилгээг авах
 - 3.6.1.2 Суралцах хэлбэрээ сонгох
 - 3.6.1.3 Судалгааны ажлын удирдагч, зөвлөх багшийг сонгоход саналаа илэрхийлж, шийдүүлэх



- 3.6.1.4 Судалгааны ажлын сэдэв сонгох
- 3.6.1.5 Гэрээнд өөрөөр заагаагүй бол судалгааны ажлын үр дүнгээр туурвисан оюуны өмчийн эзэмшигч, хамтран эзэмшигч байх
- 3.6.2 Суралцагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.6.2.1 АШУУИС-ийн дүрэм, журам, ёс зүйг чанд мөрдөж биелүүлэх
 - 3.6.2.2 Суралцагч нь элссэн улирлын эхний сард багтан удирдагчийн хамт ТСБЗГ-тай гэрээ байгуулах
 - 3.6.2.3 Сургалтын төлбөрийг жил бүрийн 9 дүгээр сарын 20 болон 2 дугаар сарын 20-ны дотор төлсөн байх
 - 3.6.2.4 Суралцагч улирал бүрийн төгсгөлд судалсан хичээлийн багц цаг, түүнд харгалзах үнэлгээг ТСБЗГ-аар хянуулж баталгаажуулах
 - 3.6.2.5 Судалгааны ажлыг эхлэхийн өмнө судалгааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрөл авах, судалгааны ажлын үр дүн, явцыг тэнхимээр хэлэлцүүлэх
 - 3.6.2.6 ТСБЗГ, бүрэлдэхүүн сургууль, тэнхимээс зохион байгуулж байгаа сургалт, эрдэм шинжилгээ, нийгэм олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох

Дөрөв. Элсэлтийн үйл ажиллагаа

- 4.1 Элсэгчдэд тавих шаардлага
 - 4.1.1 Магистрын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын боловсролтой байна.
 - 4.1.2 Докторын хөтөлбөрт элсэгч нь магистрын зэрэгтэй байна.
 - 4.1.3 Бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимийн саналд үндэслэн тухайн хөтөлбөрийн агуулга, онцлогоос хамаарсан тусгай шаардлагыг биелүүлсэн байна.
- 4.2 Элсэлтийн бүртгэл
 - 4.2.1 Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид элсэлтийн шалгалт өгнө. Элсэлтийн шалгалтын бүртгэл жилд 2 удаа буюу жил бүрийн 8 дугаар сарын 25-наас 9 дүгээр сарын 10-ны хооронд, мөн 2 дугаар сарын 1-15-ны хооронд явагдана. Элсэлтийн зарыг qp.mnnums.edu.mn цахим хуудсаар нээлттэй зарлана.
 - 4.2.2 Магистр, докторын танхимын сургалтад элсэгчдээс мэргэжлийн ба англи хэлний шалгалт авна. Магистрын цахим сургалтын элсэгчдээс нэмэлтээр компьютерын хэрэглээний суурь ур чадварын шалгалтыг цахим хэлбэрээр авна.
 - 4.2.3 Элсэлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд холбогдох материалыг бүрдүүлэн ТСБЗГ-т бүртгүүлж, АШУУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 4.3 Гадаадын элсэгчдэд тавигдах шаардлага
 - 4.3.1 Гадаадын элсэгчдээс мэргэжлийн болон монгол эсвэл англи хэлний шалгалт авна. Монгол хэлээр суралцах тохиолдолд монгол хэлний бэлтгэл сургалтад хамрагдаж болно.
 - 4.3.2 Элсэлтийн шалгалтыг хамтын ажиллагаатай их, дээд сургуулиудад эсвэл цахимаар зохион байгуулна.
 - 4.3.3 Элсэлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд шаардлагатай материалыг бүрдүүлэн, АШУУИС-ийн гадаад харилцааны газарт хүргүүлж Монгол Улсад оршин суух визний зөвшөөрлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хандан, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.




Тав. Сургалтын төлбөр

- 5.1 Доктор, магистрын сургалтын төлбөрийг АШУУИС-ийн удирдах зөвлөл батална.
- 5.2 Суралцагч орон байр, эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндийн даатгал, тээврийн болон бусад хувь хүнд хамаарах зардлыг өөрөө хариуцна.
- 5.3 Суралцагч нь сургалтын төлбөрийг элсэн орох, дамжаа ахих бүрд хугацаанд нь бүрэн барагдуулсан байна.
- 5.4 Лекц, дадлага семинарын нөхөлтийн төлбөрийг СЭЗГ, ТСБЗГ-аас батална.
- 5.5 Судалсан хичээлийн дахин шалгалтыг нэг удаа өгөх ба төлбөр нь тухайн хичээлийн багц цагийн 25 хувь байна. Дахин шалгалтандаа магистр 70, доктор 80 хувиас доош үнэлгээ авсан тохиолдолд багц цагийн төлбөрийн 50 хувийг төлж хичээлийг дахин судална.
- 5.6 Хичээлийг нөхөн судалж буй тохиолдолд тухайн багц цагийн төлбөрийг бүрэн төлнө.

Зургаа. Шилжилт хөдөлгөөн, сургалтаас чөлөөлөх


- 6.1 Чөлөө олгох
 - 6.1.1 Суралцагч хүндэтгэх шалтгааны улмаас ажлын 5 хоног дотор сургалтад хамрагдах боломжгүй бол хичээл зааж буй багшаас чөлөө авна. Түүнээс дээш хугацаатай чөлөөг ТСБЗГ-аас авна. Чөлөө авсан хичээлийг нөхөн судална.
 - 6.1.2 Суралцагч хүндэтгэх шалтгааны улмаас “Календарьчилсан төлөвлөгөө”-ний дагуу сургалтад хамрагдах боломжгүй тохиолдолд судалгааны ажлын удирдагч багш нарт танилцуулж, ТСБЗГ-аас зөвшөөрөл авна.
 - 6.1.3 Албан ёсны чөлөө аваагүй тохиолдолд суралцах эрх хүчингүй болсонд тооцож сургалтаас чөлөөлнө.
 - 6.1.4 Сургалтаас чөлөө авсан суралцагч нь хугацаандаа эргэн ирээгүй тохиолдолд сургалтаас чөлөөлнө.
 - 6.1.5 Сургалтын явцад суралцагч нь 1 жилийн хугацаагаар 1 удаа чөлөө авч болно.
 - 6.1.6 Чөлөө хүссэн суралцагчийн тухайн улирлын хичээл сонголт, багц цагийн гүйцэтгэл, сургалтын төлбөрийг ТСБЗГ-аас хянана.
- 6.2 Шилжилт хөдөлгөөн хийх
 - 6.2.1 Бусад их сургуулиас шилжин ирж буй тохиолдолд судалсан хичээлд харгалзах багц цагийг ТСБЗГ дүйцүүлэн тооцно.
 - 6.2.2 Суралцагчийн хөтөлбөр ба тэнхим хоорондох шилжилтийг нотлох баримтад үндэслэн, ТСБЗГ шийдвэрлэж, АШУУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
 - 6.2.3 Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой өргөдлийг сургалтын эхний улиралд хүлээн авч шийдвэрлэнэ.
 - 6.2.4 Хөтөлбөр ба тэнхим хооронд шилжин суралцах тохиолдолд суралцсан хугацааны төлбөрийг бүрэн барагдуулсан байх бөгөөд зөрүү хичээлийн төлбөрийг төлж, нөхөн судална.
 - 6.2.5 Суралцагч нь гадаад, дотоодын их, дээд сургуульд шилжин суралцах тохиолдолд ТСБЗГ-т албан ёсоор хүсэлт гарган шийдвэрлүүлж, АШУУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.



- 6.2.6 Дараах тохиолдолд тус сургуулиас шилжин суралцахыг зөвшөөрөхгүй. Үүнд:
 - 6.2.6.1 Тухайн хугацаанд судалсан хичээлийн төлбөрийг барагдуулаагүй
 - 6.2.6.2 Оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдан нийт судлах багц цагийн 50-иас дээш хувьд суралцсан
 - 6.2.6.3 Тус сургуулийн нэр дээр сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан.
- 6.3 Суралцагчийг дараах тохиолдолд сургалтаас чөлөөлнө. Үүнд:
 - 6.3.1 Суралцагчийн өөрийн хүсэлтээр
 - 6.3.2 Энэ журмын 6.1.3, 6.1.4, 6.2.5, 6.5 дахь заалтаар
 - 6.3.3 Сургалтын гэрээнд заасан нөхцөлүүдийг биелүүлээгүй
 - 6.3.4 Сургалтын төлөвлөгөөний дагуу хичээл, судалгаагаа хийгээгүй
 - 6.3.5 Сургалтын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй
 - 6.3.6 Гэмт хэрэг нь шүүхийн байгууллагаар тогтоогдсон бол
- 6.4 Сургалтаас чөлөөлөгдсөн тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.
- 6.5 Гадаадын иргэн суралцагч нь өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх эсвэл бусад сургууль руу шилжин суралцах тохиолдолд захирлын тушаалаар шийдвэрлэж, БШУЯ, иргэн харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас олгосон оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгож, холбогдох зардлыг суралцагчаар төлүүлнэ.

Долоо. Сургалтын зохион байгуулалт

- 7.1 Магистр, докторын сургалтын хичээлийн жил нь 15-аас доошгүй долоо хоног бүхий 2 улирлаас бүрдэх ба намар 10 дугаар сарын эхний 7 хоногийн Даваа гаригт, хавар 3 дугаар сарын эхний 7 хоногийн Даваа гаригт тус тус эхэлнэ.
- 7.2 Магистрын сургалт 2 жил буюу 4 улирал, докторын сургалт 3 жил буюу 6 улирал үргэлжилнэ.
- 7.3 Суралцагч нь “Судалгааны ажлын календарьчилсан төлөвлөгөө”-г баримталж судалгааны ажлаа хийнэ.
- 7.4 Докторант болон танхимийн сургалтын магистрант энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу нэг сэдэвт бүтээл туурвина. Магистрант нь цахимаар суралцаж буй тохиолдолд хоёрдугаар хавсралтын дагуу судалгааны төсөл бичнэ.
- 7.5 Судалгааны ажлыг хүндэтгэх шалтгааны улмаас хугацаандаа дуусгах боломжгүй тохиолдолд тухайн тэнхимийн хурлаар хэлэлцүүлж, ТСБЗГ-ын зөвшөөрлөөр магистрант 1 жилээр, докторант 1.5 жилээр сургалтын хугацааг 1 удаа сунгаж болно. Сунгуулаагүй тохиолдолд сургалтаас чөлөөлнө.
- 7.6 АШУҮИС-д хийсэн судалгааны үр дүнгээр бусад их дээд сургууль, байгууллагуудад эрдмийн зэрэг хамгаалах, бүтээл хэвлүүлэх, оюуны өмч эзэмших, судалгааг үргэлжлүүлэхийг хориглоно.
- 7.7 АШУҮИС-тай хамтарсан хөтөлбөрийн сургалтад хамрагдсан бол гадаад, дотоодын их дээд сургуульд цуглуулсан багц цагийг харгалзах хичээлийн багц цагтай дүйцүүлж болно.
- 7.8 Судалгааны ажлын сэдэв, нэг сэдэвт бүтээл нь магистрант, докторантад давхцалгүй байна.
- 7.9 Төгсөлтийн үйл ажиллагааг жилд 2 удаа зохион байгуулна. АШУҮИС-ийн захирлын тушаалаар магистр, докторын зэргийн диплом олгоно. Диплом нь энэхүү журмын гуравдугаар хавсралтад нийцсэн байна.
- 7.10 Магистрын танхимын сургалт



7.10.1 Магистрын танхимын хөтөлбөрийн агуулга 30 багц цагаас доошгүй байх бөгөөд дараах бүтэцтэй байна.

Хичээлийн төрөл	Сэдэв	Цаг
Мэргэжлийн суурь хичээл (10 багц цаг)	Судалгааны арга зүй	4 багц цаг
	Онолын хичээлүүд	6 багц цаг
Мэргэшүүлэх хичээл (12 багц цаг)	Мэргэшүүлэх хичээл	9 багц цаг
	Мэргэшүүлэх хичээл	Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим 3 багц цаг бусад сургууль, тэнхимээс судална.
Сонгон суралцах хичээл	Төгсөлтийн өмнөх сургалтад 3 багц цагийн хичээл зааж тооцуулж болно.	3 багц цаг ба түүнээс дээш
Нэг сэдэвт бүтээл туурвих	Тухайн сэдвээр	5 багц цаг
Нийт		30 багц цаг

7.10.2 Суралцах хугацаанд багц цагийг биелүүлж судалгааг хийж дуусгасан байна. Магистрын хөтөлбөрийн хугацаанд судалсан хичээлийн явцын ба шалгалтын дүнгийн дундаж хувь 70 ба түүнээс дээш тохиолдолд тухайн хичээлийг биелүүлсэнд тооцно.

7.10.3 Магистрант нь тэнхимийн өргөтгөсөн хурлаар судалгааны ажлын сэдэв, арга аргачлалыг хэлэлцүүлж батлуулна. Ил санал хураалтаар гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд баталсанд тооцох ба удирдагч, зөвлөхийг томилж, хурлын тэмдэглэлийг ТСБЗГ-т хүргүүлнэ.

7.10.4 Танхимаар суралцаж байгаа магистрант нь 1 удирдагчтай байх ба зөвлөх багштай байж болно.

7.10.5 Судалгааны ажлын ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн судалгааны ёс зүйн хяналтын хороонд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

7.10.6 Судлаач, удирдагч бусдын бүтээлээс хуулбарласан, хулгайлсан, оюуны өмчийн тухай хуулийг зөрчсөн эсэх асуудлыг судалгааны ёс зүйн хяналтын хороо хэлэлцэж шийдвэрлэнэ.

7.10.7 Судалгааны үр дүнгээр АШУҮИС-ийн нэр дээр, 1-р зохиогчоор Эрүүл Мэндийн Шинжлэх Ухаан сэтгүүлд нэг өгүүлэл хэвлүүлсэн байна. Нэмэлт өгүүлэл бусад сэтгүүлд хэвлүүлж болно.


7.10.8 Эрдэм шинжилгээний хуралд судалгааны үр дүнгээрээ хоёроос доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байна.

7.10.9 Судалгааны үр дүнг тэнхимийн хурлаар 1 удаа хэлэлцүүлж, дэмжигдсэн тохиолдолд АШУҮИС-ийн судалгааны ёс зүйн хяналтын хороонд хандаж дүгнэлт гаргуулна.

7.11 Магистрын цахим сургалт

7.11.1 Магистрын цахим хөтөлбөрийн багц цаг нь 30-аас доошгүй байх бөгөөд дараах бүтэцтэй байна.

Хичээлийн төрөл	Сэдэв	Цаг
Мэргэжлийн суурь хичээл	Судалгааны арга зүй	6 багц цаг



	Онолын хичээлүүд	6 багц цаг
Мэргэшүүлэх хичээл	Мэргэшүүлэх хичээл	12 багц цаг
Сонгон суралцах хичээл		1 багц цагаас доошгүй байна
Магистрын судалгааны төсөл бичих ажил	Тухайн сэдвээр	5 багц цаг
Нийт		30 багц цаг

7.11.2 Суралцах хугацаанд багц цагийг биелүүлж судалгааны төслийг бичиж дуусгасан байна. Магистрын хөтөлбөрийн хугацаанд судалсан хичээлийн явцын ба шалгалтын дүнгийн дундаж хувь 70 ба түүнээс дээш тохиолдолд тухайн хичээлийг биелүүлсэнд тооцно.

7.11.3 Магистрын цахим сургалтын нэгдсэн шалгалтыг ТСБЗГ зохион байгуулна. Нэгдсэн шалгалтад тэнцсэн магистрантын судалгааны төслийн чиглэлийг олон улсын цахим сургалтын тэнхим (ОУЦСТ), мэргэжлийн тэнхимтэй хамтран шийдвэрлэнэ.

7.11.4 Цахимаар суралцаж байгаа магистрант нь 1 удирдагчтай байна.

7.11.5 Суралцагч товлосон хугацаанд төслөө бичээгүй тохиолдолд 5 багц цагийн хичээлийг дараа улиралд дахин судална.


7.12 Докторын сургалт

7.12.1 Докторын сургалтын хөтөлбөрийн агуулга 60 багц цагаас доошгүй байх бөгөөд дараах бүтэцтэй байна.

Хичээлийн төрөл	Сэдэв	Багц цаг
Мэргэжлийн суурь хичээл (12 багц цаг)	Судалгааны арга зүй	6 багц цаг
	Онолын хичээлүүд	6 багц цаг
Мэргэшүүлэх хичээл (18 багц цаг)	Мэргэшүүлэх хичээл	12 багц цаг
	Мэргэшүүлэх хичээл	Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим 6 багц цаг бусад сургууль, тэнхимээс сонгон судална.
Сонгон суралцах хичээл	Төгсөлтийн өмнөх сургалтад 3 багц цагийн хичээл зааж тооцуулж болно.	6 багц цаг ба түүнээс дээш
Нэг сэдэвт бүтээл туурвих	Тухайн сэдвээрээ	24 багц цаг
Нийт		60 багц цаг

7.12.2 Суралцах хугацаанд багц цагийг биелүүлж судалгааг хийж дуусгасан байна. Докторын хөтөлбөрийн хугацаанд судалсан хичээлийн явцын ба шалгалтын дүнгийн дундаж хувь 80 ба түүнээс дээш тохиолдолд тухайн хичээлийг биелүүлсэнд тооцно.

7.12.3 Докторантын судалгааны ажлын сэдэв, арга аргачлалыг доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй 7-оос доошгүй эрдэмтдээс бүрдсэн тэнхимийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж, ил санал хураалтаар гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд удирдагч, зөвлөхийг томилон, хурлын тэмдэглэлийг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлд хүргүүлнэ.




- 7.12.4 Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөл докторантын судалгааны ажлын сэдэв, арга аргачлалыг хэлэлцэж, гишүүдийн ил санал хураалтаар 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд баталж, удирдагч, зөвлөхийг баталгаажуулж, ТСБЗГ-т хүргүүлнэ.
- 7.12.5 Докторант нь 2 хүртэл удирдагчтай, 1 зөвлөхтэй байж болно. Нэг удирдагч нь АШУҮИС-ийн эрдэмтэн, багш байна.
- 7.12.6 Судалгааны ажлын ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн судалгааны ёс зүйн хяналтын хороонд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.
- 7.12.7 Докторант нь судалгааны үр дүнгээрээ эрдэм шинжилгээний илтгэл хоёроос доошгүйг хэлэлцүүлсэн байна.
- 7.12.8 Докторант нь судалгааны үр дүнгээр хөндлөнгийн хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн олон улсын сэтгүүлд АШУҮИС-ийн нэр дээр 1-р зохиогчоор 2 ба түүнээс дээш өгүүлэл хэвлүүлсэн байна. Үүний нэг нь Web of science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд эсвэл Central Asian Journal of Medical Sciences-д хэвлүүлсэн байна.
- 7.12.9 Судалгааны үр дүнгээр дотоодын сэтгүүлд 2 ба түүнээс дээш өгүүлэл хэвлүүлнэ. Үүний нэг нь Эрүүл Мэндийн Шинжлэх Ухаан сэтгүүлд хэвлүүлсэн байна.
- 7.12.10 Судалгааны ажлын явцыг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлэх ба гишүүдийн нууц санал хураалтаар 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргад хурлын тэмдэглэлийг хүргүүлнэ. Саналын хувь хүрээгүй тохиолдолд зохих засварыг хийж тухайн Эрдмийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлнэ.
- 7.12.11 Явцын хэлэлцүүлгийн дараа судалгааны ёс зүйн хяналтын хорооны ёс зүйн дүгнэлт болон нэр томъёоны зөвлөлийн хурлын шийдвэрийг авна.
- 7.12.12 АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн дарга судалгааны багийн гишүүдтэй ашиг сонирхлын зөрчилгүй 3 шинжээчийн бүрэлдэхүүнтэй комиссыг томилж, докторантын нэг сэдэвт бүтээл, судалгаатай холбоотой эх материалд магадлан шинжилгээ хийлгэнэ.

Найм. Урьдчилсан хэлэлцүүлэг ба хамгаалалт

- 8.1 Магистрант, докторант нь магистрын сургалтын багц цагийг бүрэн судалсан, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн, сургалтын төлбөрийг бүрэн барагдуулсан тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэгт орно.
- 8.2 Магистрант, докторант нь хэлэлцүүлгийг монгол эсвэл англи хэлээр хийж болох ба тухайн хэлээрээ нэг сэдэвт бүтээлийг туурвина.
- 8.3 Магистрант, докторант нь урьдчилсан хэлэлцүүлэг, эрдмийн зэрэг хамгаалуулах хурлаар 75 хувиас доош санал авсан тохиолдолд тухайн хурлаар 2 хүртэл удаа дахин хэлэлцүүлж болно. Хэрэв дахин 2 удаа хэлэлцүүлээд хангалттай санал аваагүй тохиолдолд хөтөлбөрийн багц цагийг биелүүлсэн гэрчилгээ олгох ба эрдмийн зэргийн диплом олгохгүй.
- 8.4 Магистрын зэргийн хамгаалалт

- 8.4.1 Магистрын урьдчилсан хэлэлцүүлгийн хурлаар орох материалыг ТСБЗГ-аар хянуулж, хуралд орох зөвшөөрөл авна.
- 8.4.2 Урьдчилсан хэлэлцүүлгийг доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй 7-оос доошгүй эрдэмтдээс бүрдсэн тэнхимийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэнэ. Ил санал хураалтаар гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд албан ёсны шүүмжлэгчийг томилж, хурлын шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Саналын хувь хүрээгүй тохиолдолд зохих засварыг хийж тухайн хурлаар дахин хэлэлцүүлнэ.
- 8.4.3 Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга магистрантын нэг сэдэвт бүтээлийг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд цахимаар илгээсэн байна.
- 8.4.4 Эрдмийн зөвлөлийн хурлаар магистрантын судалгааны ажлыг хэлэлцэн шүүмжийг сонсож, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Хэрэв магистрант нь АШУУИС-ийн нэр дээр өөрийн судалгааны үр дүнгээр Web of science, Scopus, Pubmed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд 1-р зохиогчоор эсвэл эдгээр санд бүртгэлтэй, импакт фактор 3-аас дээш бүхий сэтгүүлд хамтран зохиогчоор 1 өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд ил санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 8.4.5 Санал хураалтаар Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд магистрын зэрэг хамгаалсанд тооцно. Саналын хувь хүрээгүй тохиолдолд зохих засварыг хийж тухайн зөвлөлөөр дахин хэлэлцүүлнэ.
- 8.4.6 Магистрын нэг сэдэвт бүтээлийг эх хувиар болон электрон хэлбэрээр Эрүүл мэндийн шинжлэх ухааны төв номын сан (ЭМШУТНС)-д хүлээлгэн өгнө.
- 8.5 Цахим сургалтын магистрын зэргийн хамгаалалт
- 8.5.1 Магистрын урьдчилсан хэлэлцүүлгийг доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй 7-оос доошгүй эрдэмтдээс бүрдсэн ОУЦСТ-ийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн, ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь дэмжсэн тохиолдолд албан ёсны шүүмжлэгчийг томилж, хурлын шийдвэрийг төгсөлтийн сургалтын Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Саналын хувь хүрээгүй тохиолдолд зохих засварыг хийж тухайн хурлаар дахин хэлэлцүүлнэ.
- 8.5.2 Шүүмжлэгч нь үнэлгээний хуудасны дагуу судалгааны төслийг үнэлж, төгсөлтийн сургалтын Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 8.5.3 Эрдмийн зөвлөлийн хурлаар магистрантын судалгааны төслийг хэлэлцэнэ. Гишүүдийн нууц санал хураалтын дундаж хувь 40 хүртэл байх ба тус саналд явц (20% хүртэл) болон шүүмжлэгчийн үнэлгээ (40% хүртэл)-г нэмсэн нийлбэр нь 75 хувь ба түүнээс дээш тохиолдолд магистрын зэрэг хамгаалсанд тооцно. Нийт үнэлгээ 75 хувиас доош тохиолдолд зохих засварыг хийж тухайн хурлаар дахин хэлэлцүүлнэ.
- 8.5.4 Магистрант нь төсөл бичих мэргэжлийн чиглэл солих, шүүмжлэгч багшийг дахин томилуулах хүсэлт гаргасан тохиолдолд чиглэл солих асуудлыг ОУЦСТ-ийн хурлаар, шүүмжлэгч багш дахин томилох асуудлыг төгсөлтийн сургалтын Эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.




8.6 Докторын зэргийн хамгаалалт


- 8.6.1 Докторын урьдчилсан хэлэлцүүлэгт бүрдүүлсэн материал, нэг сэдэвт бүтээлийг ТСБЗГ хянаж, хэлэлцүүлэх зөвшөөрлийг АШУҮИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга өгнө.
- 8.6.2 АШУҮИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь урьдчилсан хэлэлцүүлэг хийхээс ажлын 5 өдрийн өмнө нэг сэдэвт бүтээлийг Эрдмийн зөвлөлийн гишүүдэд цахимаар хүргүүлнэ.
- 8.6.3 Урьдчилсан хэлэлцүүлгийг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Хэрэв докторант нь судалгааны ажлаараа АШУҮИС-ийн нэр дээр 3 ба түүнээс дээш импакт фактортай Web of science, Scopus, Pubmed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд 1-р зохиогчоор 1 өгүүлэл эсвэл импакт фактор 1-ээс дээш сэтгүүлд 1-р зохиогчоор 2 өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд ил санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 8.6.4 Урьдчилсан хэлэлцүүлгээр гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь дэмжсэн тохиолдолд докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хүргүүлэх ба АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн даргын саналаар 2 эрдэмтнийг албан ёсны шүүмжлэгчээр томилно. Саналын хувь хүрээгүй тохиолдолд зохих засварыг хийж тухайн зөвлөлөөр дахин хэлэлцүүлнэ.
- 8.6.5 Албан ёсны шүүмжлэгч нь ашиг сонирхлын зөрчилгүйгээ илэрхийлж, судлаачийн ёс зүйг эрхэмлэн, судалгааны ажлын шинжлэх ухаанч байдал, шинэлэг тал, хуулбарласан эсэх, шинжлэх ухаанд оруулж буй ач холбогдол, хувь нэмэр зэргийг тусгасан шүүмж бичнэ.
- 8.6.6 Докторын зэргийн хамгаалалтыг БШУ-ны сайдын тушаалаар батлагдсан докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 8.6.7 Докторын зэргийн хамгаалалт амжилттай болсон тохиолдолд докторын нэг сэдэвт бүтээлийг эх хувиар болон электрон хэлбэрээр Үндэсний Номын Сан, Мэдээллийн Технологийн Үндэсний Парк, ЭМШУТНС-д хүлээлгэн өгнө.

Ёс. Докторын дараах судалгаа

- 9.1 АШУҮИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төслүүдтэй уялдуулан Эрдмийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хуралдаанаар докторын дараах судлаачийн тоог тогтоон, сонгон шалгаруулна.
- 9.2 Докторын дараах судалгаа нь 1-2 жил байна. Судалгааны үр дүнг үндэслэн 1 жил хүртэлх хугацаагаар сунгаж болно.
- 9.3 АШУҮИС-тай хамтын ажиллагаатай гадаад, дотоодын их сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын эрдэмтэн судлаачид хамрагдаж болно.
- 9.4 АШУҮИС-ийн тэнхим, лаборатори, хүрээлэн, их сургуулийн эмнэлгийг түшиглэн хийнэ.
- 9.5 ТСБЗГ нь докторын дараах судлаач болон удирдагчтай гурвалсан гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавина.
- 9.6 Докторын дараах судлаач, удирдагч нар судалгааны явцын үр дүнг хагас жил тутам ТСБЗГ-т тайлагнана. Судалгааны төслийн тайланг АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлж хүлээлгэн өгнө.
- 9.7 Докторын дараах судлаач нь Web of science, Scopus, Pubmed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр эсвэл хариуцлагатай зохиогчоор 1 өгүүлэл заавал хэвлүүлнэ.



- 9.8 Харьяалагдах тэнхим, удирдагчийн удирдлага дор магистрант, докторантын сургалт, судалгааны ажлыг удирдан чиглүүлнэ.
- 9.9 Докторын дараах судлаач нь багшийн зэрэглэлээр цалинжина.
- 9.10 Судлаач гэрээг зөрчсөн тохиолдолд докторын дараах судалгааны санхүүжилттэй холбоотой бүх зардлыг буцаан төлүүлнэ.
- 9.11 Докторын дараах судлаачийг их сургуулиас гадуур давхар ажил эрхлэхийг хориглоно.
- 9.12 Докторын дараах судлаачийн удирдагчид тавигдах шаардлага
 - 9.12.1 АШУУИС-ийн үндсэн багш, дэд профессор ба түүнээс дээш эрдмийн цолтой байх
 - 9.12.2 Гадаад, дотоодын болон АШУУИС-ийн санхүүжилттэй судалгааны төслийн удирдагч байх
- 9.13 Докторын дараах судлаачид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал:
 - 9.13.1 Төрийн албан хаагчийн 1-р маягт
 - 9.13.2 Докторын зэрэг хамгаалаад 5 жилээс хэтрээгүй байх
 - 9.13.3 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлийн жагсаалт
 - 9.13.4 Докторын дараах судалгааны төслийг бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжсэн хурлын шийдвэр





НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ ТУУРВИХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү үлгэрчилсэн заавраар магистр, докторын диссертац буюу нэг сэдэвт бүтээлийн бичилт, эх бэлтгэл, хэвлэх үйл ажиллагааг зохицуулна.

Хоёр. Нэг сэдэвт бүтээлд тавих ерөнхий шаардлага

- 2.1 Доктор/ магистрын нэг сэдэвт бүтээл (диссертац) нь БСШУ-ны сайдын 2007 оны 6 дугаар сарын 7-ны 187-р тушаалын нэгдүгээр хавсралт “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”-ын 16.2 дугаар заалтын шаардлагыг хангасан байна.
- 2.2 Нэг сэдэвт бүтээлийг монгол хэлээр А4 цаасны нүүрэн хэсэгт бичих ба магистрын судалгааны ажил 30-аас доошгүй, докторын судалгааны ажил 60-аас доошгүй хуудастай байна.
- 2.3 Горилогчийн хүсэлтээр нэг сэдэвт бүтээлийг англи хэлээр бичүүлж болно.
- 2.4 Нэг сэдэвт бүтээлийг урьдчилсан хэлэлцүүлэг ба жинхэнэ хамгаалалтад А4 цаасны ар өвөр хэсэгт хэвлэн тарааж болно.
- 2.5 Товч хураангуй, удиртгал, хэлцэмж, дүгнэлт, зөвлөмж, талархлын хэсэгт хүснэгт, зураг оруулахгүй.
- 2.6 Нэг сэдэвт бүтээлийн хуудасны дугаарлалт товчилсон үгийн жагсаалтаас 1-ээр эхэлж талархал хэсэгт төгсөнө.

Гурав. Нэг сэдэвт бүтээлийн бүтэц

Нүүр /1,2,3-р нүүр/

ГАРЧИГ /1-2 нүүр/

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ /1 нүүр/

ТОВЧ ХУРААНГУЙ /англи, монгол хэлээр/

УДИРТГАЛ /5-8 нүүр/

Судалгааны ажлын үндэслэл

Судалгааны зорилго

Судалгааны зорилт

Судалгааны таамаглал

Судалгааны ажлын шинэлэг тал

Судалгааны ажлын практик ач холбогдол

Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал

Судалгааны ажлыг хэвлэн нийтлүүлсэн байдал

Эрдэм шинжилгээний өгүүлэл:

Хэлэлцүүлсэн илтгэл:


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ /магистр 5 нүүр, доктор 10 нүүр/

Тухайн судалгааны сэдэвтэй холбоотой бусад эрдэмтэн судлаачийн судалгааг тусгасан тойм байдлаар бичнэ.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ /5-аас доошгүй нүүр/
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН /6-аас доошгүй нүүр/
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭЛЦЭМЖ /магистр 6-аас доошгүй нүүр, доктор 10-аас доошгүй нүүр/
СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ
ЗӨВЛӨМЖ /шаардлагатай тохиолдолд/
ТАЛАРХАЛ /дүгнэлт, зөвлөмж, талархал 1-2 нүүр/
НОМЗҮЙ /хуудасны тоонд тооцохгүй/
ХАВСРАЛТ /хуудасны тоонд тооцохгүй/

Дөрөв. Нэг сэдэвт бүтээлийн хэлбэржүүлэлт

- 4.1 Нэг сэдэвт бүтээлийг А4 цаасны 1 талд хэвлэх тохиолдолд хуудасны зүүн захаас 3 см, бусад захаас 2.5 см зайтай бичнэ. А4 цаасны 2 талд хэвлэх тохиолдолд бүх талаас 2.5 см зайтай байна.
- 4.2 Хүснэгт, зураг, гарчиг хуудас дамнах тохиолдолд шинэ нүүр хуудаснаас эхлүүлнэ.
- 4.3 Гарчгийн агуулгыг бичихдээ удиртгал, судалгааны ажлын үндэслэл, зорилго, зорилт, таамаглал, шинэлэг тал, практик ач холбогдол, судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал, судалгааны ажлыг хэвлэн нийтлүүлсэн байдал, хэвлэлийн тойм, судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй, судалгааны ажлын үр дүн, судалгааны үр дүнгийн хэлцэмж, судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмж, талархал хэсгийн эхлэх хуудасны дугаарыг тавина.
- 4.4 Нэг сэдэвт бүтээлийн нүүр
 - 4.4.1 Нэг сэдэвт бүтээлийн нүүр нь 1,2,3-р нүүрнээс бүрдэнэ
 - 4.4.2 Нүүр хуудсыг дугаарлахгүй бөгөөд загварын дагуу бичнэ.
 - 4.4.3 Нэг сэдэвт бүтээлийн нэгдүгээр нүүрт бичигдэх судлаачийн овог нэрийг шаардлагатай тохиолдолд англи хэлээр бичнэ.
- 4.5 Эх бичвэр
 - 4.5.1 Эх бичвэрт удиртгал, судалгааны ажлын үндэслэл, судалгааны зорилго, судалгааны зорилт, судалгааны таамаглал, судалгааны ажлын шинэлэг тал, судалгааны ажлын практик ач холбогдол, судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал, судалгааны ажлыг хэвлэн нийтлүүлсэн байдал, хэвлэлийн тойм, судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй, судалгааны ажлын үр дүн, судалгааны үр дүнгийн хэлцэмж, судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмж, талархал зэрэг хэсгүүд хамаарна.
 - 4.5.2 Гарчиг нь Arial (font) фонттой, 12 pt (size) хэмжээтэй, бүх үсгийг /UPPERCASE/ томоор, тодруулан (bold style), голлуулсан (center) байх ба бүлгийн дугаарыг үсгээр бичнэ. (тухайлбал: **ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГАЗҮЙ**)
 - 4.5.3 Дэд гарчиг нь Arial (font) фонттой, 12 pt (size) хэмжээтэй, тодруулж (bold), (sentence case), зүүн тал руу шахсан (align left) байх ба бүлгийн дугаарыг тоогоор бичнэ. (тухайлбал: **2.1 Хэрэглэгдэхүүн**)
 - 4.5.4 Гарчиг, дэд гарчгийн өмнө болон дараа 6 pt зай (before and after space 6 pt) авна.



- 4.5.5 Эх бичвэрийг бичихдээ догол мөрнөөс (tab-1cm) эхэлж бичих бөгөөд мөр хоорондын зай 1.5, Arial (font) фонттой, ердийн загвартай (regular style), 12 pt (size) хэмжээтэй, хоёр талдаа тэгшилсэн (Justified) байна.
- 4.6 Хүснэгт
- 4.6.1 Хүснэгт, зургийн гарчиг нь Arial (font) фонттой, тодруулсан (Bold style), 11 pt (size) хэмжээтэй, хоёр талдаа тэгшилсэн (Justified), мөр хоорондын зай 1 pt байна. Хүснэгтийн гарчгийн өмнө болон дараа 6 pt зай (before and after space 6 pt) авна.
